БАГАХАНГАЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв мян.т | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ | | | | | | | |
| **Зорилго 1: Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд:** Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг эрчимжүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулан, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, нэр төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулна. /МУХТЖТ-2.2.2, 2.2.8, МУХТЖҮЧ-2.2.1, НХТЖҮЧ-2.5, 2.6, 2.7, 2.9.1, 2.9.2, 2.11.1, НЗДҮАХ- 2.1, НХЖТ-2.1/ | | | | | | | |
| 1. 1 | Хүүхэд өсвөр үеийхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | - | Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн сургалтын тоо | - | 10 | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийг сайжруулах зорилгоор:<br>-Хүүхдүүдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох үүднээс “ Хүний папилома “Вирусын эсрэг дархлаажуулалтаар талаар сургалтыг 91,94-р сургуулийн 6-р ангийн сурагчдын дунд 2 удаа зохион байгуулан 62 сурагч НЭМГ, ДЭМБ-тай хамтран дүүргийн удирдах ажилтан ,эцэг эхчүүдэд 1 удаа зохион 78 хүнийг, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн эмч нартай хамтран 32 эцэг эхчүүдэд сургалтыг тус тус зохион байгуулсан.<br>-“Өсвөр үеэ сонсоё” аяны хүрээнд эх өваригч бага эмч Б. Энхээ 91,94-р сургуулийн 126 хүүхэд бэлгийн эрүүл ахуй талаар сургалт явуулан гарын авлага 150 ширхэг боловсруулан тараасан.<br>-Эрүүл амьдралын хэв маягийг | 100 |
| | | | Хамрагдсан иргэдийн тоо | - | 120 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэвшүүлэх замаар бага насны хүүхдийн хооллолт буюу эхийн сүүний ач холбогдол сэдэвт сургалтанд 1 эмч хамрагдсан.<br>Сургалтын үр дүнд ажилчдад 1 удаагийн сургалт, иргэдэд 3 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 48 иргэнг хамруулсан. | |
| 1.2 | Дүүргийн шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулна | Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгө, Байгууллагын төсөв | Арга хэмжээний тоо | 1 | 1 | "Эрүүл шүд" хөтөлбөрийг хэрэгжүүлэн “Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн”-ийг 2025 оны 11 дүгээр сард хийхээр төлөвлөн дүүргийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран тэмцээний удирдамж, шаардагдах төсвийн асуудлыг шийдвэрлэн Нийслэлийн Шүд Эрүү нүүрний төвтэй хамтран сургалт, тэмцээний бэлтгэл асудлыг ханган ажилласан ба Томуу томуу төст өвчний дэгдэлтээс шалтгаалан тус тэмцээний хугацаа хойшилсон. | 90 |
| | | | Хамрагдсан хүүхдийн тоо | 72 | 72 | | |
| 1.3 | Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг, мэдээлэл олгох ажлыг эрчимжүүлж, жирэмслэхээс сэргийлэх арга хэмжээг нэмэгдүүлнэ. | - | Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хувь | 62 | 85 | Эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр эмэгтэйчүүдийн 1 их эмч, эх баригч бага эмч -1 нийт 2 оронтойгоор тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.<br>Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр эх баригч бага эмч Б. Энхээ жирэмсний хяналтанд байгаа 28 эхэд шаталсан болон ганцаарчилсан сургалтыг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 42 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүнийг хамруулсан.<br><br>Эмэгтэйчүүдийн эсэн мэнд амаржихуй, жирэмсний болон дараах үеийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр 7 хоногийн Баасан гаригийн 10 цагийг эмэгтэйчүүдийн цаг болгон сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж эхлүүлээд байна.<br>Эмэгтэйчүүд гэр бүлийнхэнд зориулсан 6 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 51 иргэнд хамруулсан.<br>-Төрөх насны 15-45 насны эмэгтэйчүүдийн судалгааг нарийвчлан гаргаж 152 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан.<br>-Зорилтот бүлгийн 138 эмэгтэйчүүдээс 87 эмэгтэйг жирэмснээс хамгаалах эм , тариа , суулгацанд хамруулснаар эрсдэлт бүлгийн иргэдийн 63 хувийг жирэмснээс сэргийлэх аргад суралцуулан урьдчилан сэргийлэн ажилласан. | |
| 1.4 | Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулна. | | Зохион байгуулсан сургалтын тоо | 10 | 30 | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран амьдралын зөв дадлыг олгох, эрүүл мэндийн зөв мэдээллийг авах 27 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 328 иргэнийг хамруулсан.<br>-Нийгмийн эрүүл мэндийн үйл | 100 |
| | | | Хамрагдсан иргэдийн тоо | 568 | 650 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг тогтмолжуулах чанарыг сажйруулах зорилгоор 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс НЭМ-ийн эмчээр Г.Болдыг томилон ажиллуулсан.<br>-Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл хүргэх зорилгоор байгууллагын вэб сайт болон цахим хуудсанд 34 төрлийн 573 мэдээлэл, зөвлөмжийг байршуулж түгээсэн ба хандалт 9856 байна.<br>-Хэвтэн эмчлүүлэгч нартаа зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлэн 7 хоногийн пүрэв гаригийн 10 цагийн эрүүл мэндийн цаг болгож сургалтын ажлыг эрчимжүүлсэн. Хэвтэн эмчлүүлэгч нарт 13 төрлийн сэдвээр шаталсан сургалтыг зохион байгуулсан.<br>-2025 оны 11 дүгээр сарын 03-наас эмэгтэйчүүдийн эмчтэй болсноор иргэдэд нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлт сэдэвт сургалтын үйл ажиллагааг тогтмолжуулж 7 хоног бүрийн баасан гаригийн 10 цагт эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулж ажиллаж байна. Эмэгтэйчүүд гэр бүлийнхэнд зориулсан 6 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 51 иргэнд хамруулсан.<br>-Байгууллагуудын ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгт 7 байгууллагын 246 албан хаагчид үзлэгт хамрагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | Сүрьеэ өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна. | - | 10,000 хүн амд ногдох илрүүлэлт /промиль/ | 7,2 | 5 | ДЭМБ, сүрьеэгийн нийгэмлэгтэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 19, 20-ны өдөр сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт 114 иргэнийг хамруулснаас 21 иргэдээс цэрний шинжилгээний сорьц авч ХӨСҮТ-д хүргэн онош тодруулах шинжилгээнд хамруулж ажилласан.<br>2025 оны 11 сарын байдлаар шинээр сүрьеэ өвчний тохиолдол 1 илэрч эмчилгээндээ хамруулсан.<br>Мөн 2 тохиолдол эдгэрч хяналтаас хасагдсан. | 100 |
| | | - | Шинээр илэрсэн халдварын эмчилгээний амжилтын хувь | 75 | 82 | | |
| 1.6. | БЗДХ-ийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна. | - | 10,000 хүн амд ногдох илрүүлэлт /промиль/ | 8.9 | 4.0 | 2025 оны эхний 11 сарын байдлаар БЗДХ/ДОХ халдварт өвчнийг, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулан 816 иргэнийг хамруулан ажилласан.<br>Эргэлзээтэй гарсан -6 шинжилгээг ХӨСҮТ-д баталгаажуулахаар илгээхэд хариу сөрөг гарсан байна.<br>2025 оны эхний 11 сарын байдлаар 6 иргэнийг ХӨСҮТ–д баталгаажуулах шинжилгээнд явуулсан.<br>Баталгаажсан тохиолдол бүртгэгдээгүй байна . | 100 |
| | | - | Шинээр илэрсэн халдварын эмчилгээний амжилтын хувь | 62.0 | 85 | | |
| 1.7 | Товлолт дархлаажуулалт хамрагдалтыг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулж дархлаажуулалтын урвал хүндрэлээс сэргийлэх ажлыг зохион байгуулна | - | Товлолт дархлаажуулалтын хамрагдалтын хувь | 91.2 | 99 | 2025 оны эхний 11сарын байдлаар нийт товлолын 0-2 насны дархлаажуулалтанд 283 хүүхэд хамрагдахаас 269 хамрагдаж, 95хувьтай хийгдсэн. Үүнээс 9сартай, 2 настай УГУ ын дархлаажуулалт | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хоцорсон 115 хүүхдийг хамруулж нөхөн дархлаажуулалт 77хувьтай. 11 настай хүний папилома вирусын эсрэг дархлаажуулалт 79 хүүхэд хамрагдаж 79.7 хувьтай, 7.15 настай сахуу татран өвчний дархлаажуулалтанд 83 хүүхэд хамрагдахаас 78 хамрагдаж93.9 хувьтай тус тус хамрагдсан. Дархлаажуулалтын иргэд сурталчлах эерэг мэдээлэл түгээх ажлын хүрээнд дархлаажуулалтын 7 хоногийг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд НЭМҮТ-ийн багш нартай хамтран 11 настай хүүхдүүдийн эцэг эхчүүдэд зориулсан сургалтыг 91,94-р сургууль дээр зохион байгуулан 68 хүнийг хамруулсан. Их эмч Э.Түвшинжаргал, вакцинатор сувилагч О.Удвал нар 8 байгууллагын 326 албан хаагчид дархлаажуулалт ач холбогдол, Хүний папилома вирусын дархлаажуулт сэдвээр сургалт зохион байгуулан ажилласан. | |
| 1.8 | Дархлаажуулалтын 10 хоног, сайн дурын дархлаажуулалтын ажлыг чанартай зохион байгуулж хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгө, Байгууллагын төсөв | Хамрагдалтын хувь | 93.8 | 98 | 2025 оны дархлаажуулалтын 10 хоногийг 9 дүгээр сарын 25-наас 10 дугаар сарын 05 ны зохион байгуулан ажилласан.<br>Аяны хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнтэй хамтран 6 ангийн эцэг эхчүүдийн дунд хүний папилома вирусын талаар сургалт 2 удаа зохион байгуулагдаж 69 иргэн хамрагдсан.<br>-Дархлаажуулалтанд 2024 оны 11 настай -15 хүүхэд, 2025 оны 11 настай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -77, 12-14 насны 1 нийт -92 хүүхдийг хамруулан ажилласан.<br>-Мөн 9 сартай, 2 настай улаанбурханы дархлаажуулалтаас хоцорсон-77, хүүхэд, бусад товлолоос хоцорсон -5 хүүхдийг нөхөн дархлаажуулалтанд хамруулан А аминдэмийг 86 хүүхдэд уулгаж ажилласан.<br>-Дархлаажуулалтын 10 хоногийн хүрээнд томуугийн дархлаажуулалт 400 хүн тун хийгдэхээс зорилтот бүлгийн 400 хийгдэж дархлаажуулалт 100%-тай.<br>-Сахуу татрангийн 7,15 товлолын дархлаажуулалтанд 128 хамрагдахаас 121 хүүхэд хамрагдаж 94,5 хамрагдсан. | |
| 1.9 | "Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлж, сургуулийн өмнөх боловролын байгууллагын болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагсдыг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | - | Хамтран ажилласан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тоо | 1 | 1 | Дүүргийн иргэдэд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэх зорилгоор НШЭНТ-тэй хамтран ажиллах гэрээг 2025 онд сунгасан.<br>-Эмальдент ХХК шүдний эмнэлэгтэй 2025 оны 01 дүгээр сарын 02-ноос хамтран ажиллах гэрээг сунган гэрээний хэрэгжилтийн хүрээнд 7 хоног бүрийн мягмар гаригт тогтмол үзлэгийг зохион байгуулахыг үүрэг чиглэл өгч ажилласан.<br>-2025 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар нийт 238 хүн тусламж үйлчилгээ үзүүлснээс амны хөндийн өвчлөл 75%-ээзлж байна.<br>-Эрүүлжүүлэлтийн төлөвлөгөөг гарган | 100 |
| | | | Урьдчилан сэргийлэх үзлэгт орсон хүүхдийн тоо | 579 | 600 | | |
| | | | Эмчилгээнд хамрагдаж эрүүлжсэн үзлэгийн хувь | 80,7 | 80 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмчилгээг хийж ажилласнаар эрүүлжүүлэлт 67%-тай байна.<br>-Гэрээний хэрэгжилтийн хүрээнд хиймэл шүд шаардлагатай шинээр 21 хүнд, давтан 24 хүнд тус тус хиймэл шүд хийсэн.<br>-Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 44-р цэцэрлэгт 02 сард урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж 133 хүүхдийн хамруулсан.<br>-Нийслэлийн Шүд Эрүү Нүүрний төвийн эмч нар 2025 оны 10 дугаар сарын 17-ноос 10 дугаар сарын 21-ний хооронд дүүрэгт амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж 352 хүн үзснээс 1 жирэмсэн эмэгтэй, 3 ахмад настан, 348 хүүхдийг хамруулж эмчилгээ хийж, зөвлөгөө өгч ажилласан. | |
| 1.10 | Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ оношилгоонд хүн амыг хамруулах ажлыг чанартай зохион байгуулна. | - | Эрт илрүүлгийн хамрагдалтын хувь | 69.2 | 72 | Амны хөндийн эрүүл мэндийн зөв дадлыг олгох чиглэлээр:<br>- Ерөнхий боловсролын сургуультай хамтран хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн сэдвээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулж 144 хүүхдийг хамруулсан.<br>- 44, 207 дугаар цэцэрлэгтэй хамтран багш ажилчдад зориулсан тус бүр 1 удаагийн сургалтыг зохион байгуулж 41 ажилтан хамрагдсан.<br>- Аж ахуйн нэгж байгууллагад 4 удаа сургалт зохион байгуулж нийт 128 ажилчдыг хамруулсан.<br>Байгууллагын цахим хуудас болон вэб | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сайтанд 8 төрлийн зөвлөмжийг байршуулж түгээж ажилласан ба хандалт 2450 байна. | |
| 1.11 | Нөхөн үржихүйн эмэгтэйчүүдийн судалгааг гаргах, жирэмсэн эхчүүдийг эрт хяналтын хувийг нэмэгдүүлэх, хавсарсан өвчтэй эхчүүдийн хяналтыг сайжруулна. | - | Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эмэгтэйчүүдийн хувь | 87.3 | 90 | Эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр эмэгтэйчүүдийн 1 их эмч, эх баригч бага эмч -1 нийт 2 оронтойгоор тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.<br>2025 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар нийт жирэмсний хяналтанд 53 жирэмсэн орсон эхний 3 сартай хяналт 44 буюу 83 хувьтай хяналтанд орсон жирэмснээс В,С вирус болон ХДХВ тэмбүүгийн өвчлөл илрээгүй байна.<br>Мөн онцгой хяналтанд байсан 2 ихэр жирэмсэн-2, хавсарсан эмгэг өөрчлөлттэй -6 нийт -6 жирэмсний хяналтыг дээд шатны эмнэлгийн хамтран хийж, 2 эх эсэн мэнд амаржсан. | 95 |
| 1.12 | Бага насны хүүхдийн суурь өвчлөл хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэн, эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх замаар эндэгдлийг бууруулна. | - | Эрүүлжилтийн хувь | 32.5 | 80 | 2025 оны 11сарын байдлаар 5246 хүүхдийн жин өндрийг үзэж хяналтын үзлэгийг хийж өсөлтийн хоцрогдолтой 2 хүүхдийг хяналтанд авч 1 хүүхдийн байнгын асаргаанд оруулж , 1 хүүхдийг сувилалд явуулсан. 5.11-р саруудад 0-5 насны давхардсан тоогоор 821 хүүхдэд А витамин уулгаж, 576 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй 8 хүүхдийг гэрээр эргэж, өдрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмчилгээнд хамруулсан. Улиралын томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 0-5насны 216 хүүхдийг томуугийн дархлаажуулалт хамруулан ажилласан. Мөн цаг үеийн байдалтай томуу томуу төст өвчин ихэсэж байгаатай холбогдуулан шим тэжээл хоол хүнс идэх, дархлааг дэмжих , амин дэмийг хэрхэн зөв хэрэглэх талаар 321 хүүхдэд зөвлөгөө , зөвлөмж өгч ажилласан..<br>Эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх замаар бага насны хүүхдийн хоололт буюу эхийн сүүний ач холбогдол сэдэвт сургалтанд 1 эмч хамрагдсан.<br>Сургалтын үр дүнд ажилчдад 1 удаагийн сургалт, иргэдэд 3 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 48 иргэнг хамруулсан. | |
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт 2:** Хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран хэрэгжүүлэх замаар Нийгмийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 2.1 | Худалдан авах үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Лабораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор:<br>-Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 24,278,125 төгрөгний өртөгтэй цусны хагас автомат анализаторийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүлээн авч тусламж үйлчилгээндээ ашиглаж байна. Тус | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чанартай гүйцэтгэж ажиллана. | | | | | аппаратны хяналтыг 1 удаа нийлүүлсэн байгууллага Итгэл эрүүл мэнд ХХК-аар хийлгэсэн.<br>-Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 39,337,000 төгрөгний өртөгтэй биохимийн аппаратыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Сүвэн Уул ХХК-ны инженерүүд ирж угсралт, тохиргооны ажлыг хийж ажилласан ба 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Улсын Архивын үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд архивын өрөөний стандартын дагуу тохижуулахад шаардлагатай 4 төрлийн бара материалыг худалдан авахдаа 4 байгууллагаас үнийн дүнгийн саналыг авч дүгнэлт хийн ажилласнаар шууд худалдан авах гэрээгээр 1,687,000 төгрөгний худалдан авалтыг зохион байгуулсан. | |
| 2.2 | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.6 дахь заалт “Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлэх, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх”, ногоон худалдан авах ажиллагааг зохион байгуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | “Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлэх, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх”, ногоон худалдан авах ажиллагааг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 3 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг ханган хоол үйлдвэрлэлийн хэсэгт шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн, ахуйн бараа материалыг худалдан авч ажиллаж байна. | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байгууллагын үйл ажиллагаанд дотоодын үйлдвэрийн 14 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг тогтмол худалдан авч ашиглаж байна. | |
| 2.3 | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Дотоодын үйлдвэрээс бараа, материал худалдан авах” 90 дүгээр тогтоолын дагуу чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | “Дотоодын үйлдвэрээс бараа, материал худалдан авах” 90 дүгээр тогтоолын дагуу хэрэгжилтийг ханган байгууллагаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж Их уул ХХК-д 29 ажилчдын хувцасыг худалдан авсан.<br>• Хэвлэмэл бүтээгдэхүүнээс 4 нэр төрлийн албан бланк 275,150 төгрөгөөр худалдан авалт хийсэн.<br>• 24 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг 19,077,280 төгрөгөөр худалдан авалт хийсэн. | 100 |
| **Зорилт 3.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт -** Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, авлигаас урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. /АХ-1.3.1з 0, 2.2.21, МУХЖТ-1.3.1, 2.2.1/ | | | | | | | |
| 3.1 | Нийслэл, дүүргийн зорилтод жилтэй уялдуулан ажил арга хэмжээг шинэлэг хэлбэрээр төлөвлөн зохион байгуулна. | - | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь | 98 | 98 | Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилтот жилийн хүрээнд:<br>- ДЭМБ, сүрьеэгийн нийгэмлэгтэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 19, 20-ны өдөр сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт 114 иргэнийг хамруулснаас 21 иргэдээс цэрний шинжилгээний сорьц авч | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ХӨСҮТ-д хүргэн онош тодруулах шинжилгээнд хамруулж ажилласан.<br>- Баян зүрх дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын албаны үйл ажиллагаатай туршлага солилцож арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 28-наас 30-ны хооронд 3 өдөр чанарын менежерийг ажиллуулсан.<br>- Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр 5 хүний бүрэлдэхүүнтэй туршалга солилцох уулзалтыг зохион байгуулсан.<br>Туршлага солилцох арга хэмжээгээр: Даатгал, Чанарын алба, амбулаторийн тусламж үйлчилгээ, Нийгмийн эрүүл мэндийн төв, 4-р хорооны өрхийн эрүүл мэндийн төв, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний хэсэг, түргэн тусламжийн хэсгийн үйл ажиллагаатай танилцаж эмч нарын уулзалт ярилцлагыг зохион байгуулсан.<br>- НЭМГ-тай Сувилахуйн тусламж үйлчилгээг танилцуулах өдөрлөг 2025.04.10 ны өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулж, тус арга хэмжээнд байгууллагын үйл ажиллагаа, Сувилахуйн тусламж үйлчилгээг сурталчлах, хүний нөөцийн сул ажлын байрны мэдээллийг хүргэх, ажилчдын нийгмийн баталгаа, байгууллагын давуу тал, 2025 онд сувилахуйн тусламж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээнд хэрэгжүүлж байгаа шинэлэг ажил зэргийг танилцуулж, эрүүл мэндийн байгууллагаас харилцан туршлага судалж, өөрийн байгууллагад нутагшуулж,түгээн дэлгэрүүлэх зорилгоор оролцсон.<br>- УХТЭ-ийн чих хамар хоолойн эмч нарын үзлэгийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан. Үзлэгт 114 хүүхдийг хамруулж 38 хүүхэд зөвлөгөө өгч 14 хүүхдийн нарийн мэргэжлийн эмч үзүүлэхийг зөвлөсөн.<br>- Өргөө амаржих газрын нарийн мэргэжлийн эмч нарыг үзлэгийг 2025 он 09 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж нийт 44 эмэгтэй үзлэг хамрагдаж 8 эмэгтэйг нарийн шинжилгээ хийлгэхээр цаг өгч, 2 жирэмсэн эмэгтэйг хэвтэн эмчлүүлэх захиалгад оруулж асуудлыг шийдвэрлэсэн.<br>- Нийслэлийн Шүд эрүү нүүрний төвийн эмч нар 2025 оны 10 дугаар сарын 17-ноос 21-ний хооронд эмчилгээ эрхлэсэн орлогч Б.Эрдэнэсайханаар ахлуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж ажилласан.<br>Үзлэгт нийт 352 иргэн хамрагдснаас:<br>- Жирэмсэн эмэгтэй-1<br>- Ахмад настан -3 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хүүхэд -348 үзлэг, шаардлагатай эмчилгээг хийж зөвлөгөө өгч ажилласан. | |
| 3.2 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дүүргийн дэд хөтөлбөр”-ийн хүрээнд жендэр хариуцсан ажилтныг ажиллуулах, жендэрийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэхэд сургалтад ажилтан албан хаагчдыг хамруулна. | - | Зохион байгуулсан арга хэмжээ | 1 | 1 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд арга хэмжээний хариуцах ажилтнаар хүний нөөцийн ажилтанг үүрэг чиглэл өгч ажиллаж байна.<br>“Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамж, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох” заалтыг байгууллагын дотоод журмын 3 бүлгийн 3.7 дахь заалтанд тусгасан.<br>Ажлын байранд зөрчил дутгадал бүртгэгдээгүй.<br>НЭМГ-аас зохион байгуулсан жендэрийн эрх тэгш байдал сэдэвт сургалтанд 3 ажилтан хамрагдсан.<br>Байгууллагын ажилчдын мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр 7 хоног бүрийн Лхагва гариг дотоодын сургалтыг зохион байгуулж хэвшүүлсэн ба эрүүл идэвхтэй амьдралын мэдлэг хандлага, ажлын байрны стресс, жендэрийн ойлголтыг хүргэх чиглэлээр 7 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 176 ажилтан хамрагдсан. | 95 |
| 3.3 | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх оныхоос | - | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | Байгууллагын удирдлага нийт 2025 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар нийт 33 өргөдлийг хуулийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | болгиносох, иргэдэд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг иргэнд эргэн мэдээлэх ажлыг чанаржуулах, байгууллагын өргөдөл, гомдлын тохиолдлыг өмнөх оныхоос бууруулах чиглэл ажлуудыг зохион байгуулна. | | | | | хугацаанд шийдвэрлэж ажилласан.<br>Иргэдээс өргөдөл санал хүсэлтийг бичгээр, цахимаар, биечлэн уулзаж, нэгдсэн төв зэрэг хэлбэрээр хүлээн авсан.<br>Шийдвэрлэлтийн хувь 100%, дундаж хоног 5 хоног байна.<br>Нийт ирсэн 33 өргөдлийг ангилахад талархал 16 буюу 48,5%, санал 7 буюу 21,2%, хүсэлт 8 буюу 24,2%, гомдол 2 буюу 6,1%-тай байна.<br>2025 оны 11 дүгээр сарын байдлаар<br>- Саналын хуудсаар 359<br>- Цахим санал хүсэлт -86<br>- Ганцаарчилж уулзалт хийж хүлээн авсан 42 нийт 287 санал хүсэлтийг хүлээн авсан.<br>Санал хүсэлтийн үр дүн эерэг сэтгэл ханамж 88%-тай 2024 оны мөн үетэй харьцуулахад эерэг сэтгэл ханамж 1,3%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй гарсан.<br>Үйлчлүүлэгчээс ирсэн нийт 63 санал хүсэлтээс богино хугацаанд санхүү зарцуулагдахгүйгээр шийдвэрлэх боломжтой 37 саналыг бүрэн шийдвэрлэж зохион байгуулалтыг хийсэн, хөрөнгө санхүү шаардагдах 19, боловсон хүчний талаар 7 тус тус санал бүртгэгдсэн.<br>Иргэдэд өргөдөл, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар хариу мэдээлж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4 | Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдад зориулсан дотоодын сургалт, эмч, эмнэлгийн ажилчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын байранд дадлагажуулах ажлуудыг зохион байгуулна. | - | Сургалтын тоо | 32 | 35 | Баян зүрх дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын албаны үйл ажиллагаатай туршлага солилцож арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 28-наас 30-ны хооронд 3 өдөр чанарын менежерийг ажиллуулсан.<br>Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр 5 хүний бүрэлдэхүүнтэй туршалга солилцох уулзалтыг зохион байгуулсан.<br>Туршлага солилцох арга хэмжээгээр: Даатгал, Чанарын алба, амбулаторийн тусламж үйлчилгээ, Нийгмийн эрүүл мэндийн төв, 4-р хорооны өрхийн эрүүл мэндийн төв, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний хэсэг, түргэн тусламжийн хэсгийн үйл ажиллагаатай танилцаж эмч нарын уулзалт ярилцлагыг зохион байгуулсан.<br>Байгууллагын дотоодын сургалтыг 7 хоног бүр зохион байгуулж ажилладаг ба дотоодын сургалтыг зохион байгуулах хуваарийг 2025 онд байгууллагын даргын 2025 оны А/06, А/46 дугаар тушаалаар хагас жилээр батлан хэрэгжилтийг ханган ажилласнаас 11 дүгээр сарын 24-ний байдлаар 33 удаагийн сургалтыг ажлын байранд зохион байгуулсан. Сургалтанд бүх ажилчид хамрагддаг ба давхардсан тоогоор 825 ажилтан хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Баянзүрх дүүргийн ЭМТ, Багануур дүүргийн ЭМТ-тэй хамтран эмч, эмнэлгийн ажилчдын туршлага солилцох арга хэмжээг 2025 оны 05,06 дугаар сард зохион байгуулсан.<br>Холбогдох байгууллагаас зохион байгуулсан танхимын 46 удаагийн сургалтанд 38 ажилтан, цахимаар зохион байгуулсан 23 нийт 69 сургалтанд холбогдох ажилчдын хамруулсан. | |
| 3.5 | Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах, өөрчлөх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж , ёс зүйн зөрчлийг бууруулна. | - | Сургалтын тоо | 6 | 7 | АШУҮИС-ын Сувилахуйн сургуулийн Мөнхханд багш урилгаар ирж 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр “Байгууллагын харилцаа” ёс зүйн сургалтыг зохион байгууллаа.<br>Байгууллагын дотоод сургалтын цаг дээр дарга, Хүний нөөц-Дотоод хяналтын ажилтан, Чанарын менежер нар ажилчдад зориулж 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан | 100 |
| | | | Арга хэмжээний тоо | 1 | 1 | | |
| | | | Хамрагдсан ажилчдын тоо | 28 | 31 | | |
| 3.6 | Байгууллагын ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, тусгай төлөвлөгөөтэй ажиллана. | - | Арга хэмжээний тоо | 3 | 4 | Байгууллагын ёс зүйн дэд хороог А/19 дүгээр тушаалаар 3 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан.<br>Байгууллагын соёлыг дээшлүүлэх, ёс зүйн чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг 2 бүлэг 23 заалттайгаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласнаар хэрэгжилт 96%-тай хэрэгжсэн<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд: - АШУҮИС-ын Сувилахуйн сургуулийн Мөнхханд багшийг урилгаар авчирч | 95 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд үйлчлүүлэгч болон хоорондын харилцаан дээр юуг анхаарах талаар мэдээлэл хүргэх “Байгууллагын соёл” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.<br>- Байгууллагын дотоод сургалтын цаг дээр дарга, Хүний нөөц-Дотоод хяналтын ажилтан, Чанарын менежер нар ажилчдад зориулж 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан<br>- Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар 487 санал хүсэлтийг хүлээн авч дүгнэлт хийхэд эерэг сэтгэл ханамж 88%-тай.<br>- Ёс зүйн дэд хороо нь 2025 онд 6 удаагийн хурлыг зохион байгуулж эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой 2 гомдол, 4 зөрчлийг хэлэлцэж шийдвэрлэсэн.<br>Байгууллагын даргын 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/52 дугаар тушаалаар “Ёс зүйн зөрчлийг үл тэвчье” 2 сарын аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд ажилчдын харьцаа хандлага, ажлын байранд идэвхжүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгалыг бүрдүүлэх чиглэлээр 3 төрлийн контент, 2 удаагийн сургалт, 7 хоног бүр уриатай ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.7 | Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр шинэчлэн батлагдсан хууль, тогтоомж, журам байгууллагын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | 95 | 95 | Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх “Нийгмийн баталгааг ханган” төлөвлөгөөг 21 заалттайгаар боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд:<br>- Ажилчдын нийгмийн баталгааг хангаж тогтвор суурьшилтай ажиллах зорилгоор Засгийн газрын тогтоол, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилчдад төрийн алба хаасны нэмэгдэл, орон нутгийн нэмэгдлийг 20%-иар, хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган илүү цаг, баярын цаг, шөнийн цагийн нэмэгдлийг сар бүр, ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн урамшууллыг 60 хүртлэх хувиар тооцон тогтмол олгож ажиллаж байна.<br>- Дүүргийн засаг даргын тамгын газраас олгож байгаа орон нутгийн нэмэгдлийг 6 эмчид 2025 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар 12,663,120 төгрөг зарцуулаад байна.<br>- Дүүрнийн ЗДТГ-тай хамтран төрийн албан хаагчийн байранд 2 их эмч, 1 сувилагчийг амьдрах нөхцлийг бүрдүүлсэн. | 100 |
| 3.8 | Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн хэрэгжилтийг ханган архивын улсын үзлэгийн бэлтгэл бэлэн байдлыг хангана. | - | Тайлангийн хэрэгжилтийн явц | - | 95 | Архив, бичиг хэргийн ажилтанг 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс шинээр авч ажиллуулж байна.<br>Байгууллагын даргын 2025 оны улсын 2025 оны үзлэгт бэлтгэл ажлыг хангах | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/38 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан.<br>Улсын архивын үзлэгийн шалгуур үзүүлэлт, ЗДТГ-аас ирсэн ажлын хэсгийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган архивын улсын үзлэгт бэлтгэх ажлыг чанартай хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө боловсруулан, ажил үүргийг хуваарь гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. ҮҮНД:<br>- Дүүргийн архивт 2016-2024 оны байнга хадгалагдах баримтыг БНШАЗК-ын хурлаар данс бүртгэлийг батлуулж баримтыг шилжүүлсэн.<br>- Байгууллагын архивын тооллогыг хийж баримт нягтлан шалгах, стандарт зааврын дагуу баримтуудыг үдэж хавтасласан<br>- Архивын өрөөг стандартын дагуу тохижуулах зорилгоор тохижилтын ажилд 2,411,900 төгрөг<br>- Бичиг хэргийн зардалд 2,550,450 төгрөг шийдвэрлэж зарцуулсан.<br>- Улсын архивын үзлэгт 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр ажлын хэсэг ирж ажилласан ба 87,8% үнэлэгдсэн.<br>- Архивын үйл ажиллагааны нийтлэг журмын хэрэгжилтийг ханган нөхөн бүрдүүлэлтийг цаг хугацаанд сайн чанартай хэрэгжүүлсэн гэж “Батламж” ЗДТГ-аас | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ажлын хэсгийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган 2025 он 10 дугаар сарын 27-ноос 11 дүгээр сарын 07-ны хооронд ажлуудыг зохион байгуулсан. - Дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан Архив, албан хэрэг хөтлөлтийн 2 удаагийн сургалтанд 3 ажилтан хамрагдсан.<br>Байгууллагын дотоодын сургалтаар ажилчдад зориулсан 2 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 38 ажилтан хамрагдсан. | |
| 3.9 | ERP archive, ERP Edoc, программд хяналт тавьж, ирсэн, явуулсан бичгийг зөрчилгүй шийдвэрлэнэ. 2024 оны зөрчлийн тоог бууруулж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 98 | 100 | Архив, албан хэрэг хөтлөлтийн Erp.ulaanbaatar.mn программаар нийслэл болон дүүргийн харьяа байгууллагуудаас 574 бичиг, байгууллагын мэйл хаяг, шуудан холбоогоор 69 бичиг ирснийг хүлээн авч бүртгэж шийдвэрлэгдсэн.<br>• Хариутай бичгийн шийдвэрлэлт 99,54%<br>• Хариугүй бичгийн шийдвэрлэлт 99,9%<br>• Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн дундаж 96%<br>• Албан шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4,4 хоногтой байна.<br>• Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил-24 | 95 |
| 3.10 | Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан баримт бичгийн MNS 5140-1,2,3:2021, MNS | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | - | 95 | Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан баримт бичгийн MNS 5140-1,2,3:2021, MNS 6395:2022 стандартын хэрэгжилтийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 6395:2022 стандартын хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. | | | | | ханган Нийслэлийн Архивын газарт:<br>- Тушаал<br>- Хурлын тэмдэглэл<br>- Албан А5, А4 монгол бичгийн бланкыг захиалж авсан.<br>Монгол бичиг хөрвүүлэлтийн КИМО программыг худалдаж авсан. Хос бичгийг ашиглан байгууллагын даргын тушаал, албан бичиг, хурлын тэмдэглэлийг стандартын дагуу 2025 оны бичиг баримтыг бүрэн хөрвүүлж ашиглаж байна. | |
| 3.11 | Өөрийн байгууллагын чиг үүргийн хүрээнд шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль, журмыг албан хаагчдад таниулах, сургалт зохион байгуулах, холбогдох нэгжид хагас бүтэн жилээр тайлагнана. | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 2 | 4 | Байгууллагын дотоодын сургалтанд тулгуурлан ажилчдад шинээр батлагдсан тушаал шийдвэрийг танилцуулах чиглэлээр:<br>- Нийгмийн даатгалын тухай хууль,<br>- Цалингийн шинэчилсэн тогтоол, журам,<br>- Байгууллагын дотоод журам<br>Эмнэлгийн тусламжийн чиглэлээр гарсан 7 тушаал, 3 зааврыг танилцуулах 12 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 3.12 | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах. | - | Мэдээний тоо | 12 | 12 | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж эхний хагас жилд эм, эмнэлгийн хэрэгсэлд үүссэн байсан өрийг 8 дугаар сарын 01 ний дотор бүрэн барагдуулсан ба сүүлийн хагас жилд өр төлбөр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллаж байна. | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.13 | 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд ирүүлэх. | - | Төсвийн төсөөлөл өгсөн тоо | 1 | 1 | Байгууллагын үйл ажиллагааны 2026 оны төсвийн төслийг холбогдох заавар журмын дагуу боловсруулж хуулийн хугацаанд НЭМГ-т хүлээлгэн өгч ажилласан. | 100 |
| 3.14 | 2026 оны тогтмол зардлын төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд ирүүлнэ. | - | Төсвийн төсөөлөл өгсөн тоо | 1 | 1 | Байгууллагын үйл ажиллагааны тогтмол зардлын 2026 оны төсвийн төслийг холбогдох заавар журмын дагуу боловсруулж хуулийн хугацаанд дүүргийн ЗДТГ-т хүлээлгэн өгч ажилласан. | 100 |
| 3.15 | Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.2 дахь заалтын дагуу өндөр насны тэтгэвэрт гарч байгаа албан хаагчдын болон ЭМТ тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.5 дахь заалтын дагуу өрх тосгоны эрүүл мэндийн төвд тогтвор суурьшилтай ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн материалыг бүрдүүлэн тооцооллыг хийж даргын тушаалаар батлуулан ирүүлж бодогдсон тэтгэмжийг олгоно. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | 100 | Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.2 дахь заалтын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр өндөр насны тэтгэвэрт гарсан 1 сувилагчийн нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн материалыг бүрдүүлэн тооцооллыг хийж байгууллагын даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар 27,623,468.75 төгрөгний мөнгөн тэтгэмжийг хугацаанд нь олгосон. | 100 |
| 3.16 | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд ирүүлнэ | - | Мэдээний тоо | 12 | 12 | Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 01-ний өдөр НЭМГ болон дүүргийн ЗДТГ-ын СТСхэлтэст тус бүр тайлагнаж ажиллаж байна. Хугацаа хоцроосон болон тайлагнаагүй сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байхгүй. | |
| 3.17 | 2024 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | 100 | Төсвийн улирлын гүйцэтгэл, санхүүгийн тайланг улирал бүр хуулийн заасан хугацаанд НЭМГ, дүүргийн ЗДТГ-т тайлагнаж ажилласан.<br>Байгууллагын 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр тайлагнасан.<br>Байгууллагын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 05 тоот албан бичгээр Өлзийт Экаунт аудитын байгууллагад санхүүгийн тайланг хүргүүлэн ажилласан.<br>Аудитын байгууллагаас шаардлагатай баримт, тодруулгыг цаг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.<br>Аудитын байгууллагын дүгнэлт, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг 19 заалттайгаар боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Анализ старт АУДИТ ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгууллан гэрээний хэрэгжилтийг ханан эхний 3 улирлын санхүүгийн баримтанд аудит хийгдэж байгаа болон холбогдох баримтыг хугацаанд тухай бүр өгч мэдээллээр хханган иажиллаж байна. | 95 |
| 3.18 | Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар | - | Цахим системд тайлагнасан төсөл арга хэмжээний тоо | - | Төсвийн жил дууссан нийт | “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажилллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажилллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдснаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана. | | | | төсөл, арга хэмжээг системд бүрэн тайлагнасн байна. | худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган эм, эмнэлгийн хэрэгслийг 82 орчим хувийг цахим худалдан авалтыг хийж байна. | |
| 3.19 | Хүүхдийн тусламж, үйлчилгээний чиглэлээр эмч, мэргэжилтний мэдлэг ур чадварыг үнэлэх, дадлагажуулах сургалт зохион байгуулна. | - | Хамрагдсан эмчийн тоо | | 2 | Хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр эмч нарт зориулсан ЭХЭМҮТ-өөс зохион байгуулсан 4 удаагийн сургалт 1 эмчийг бүрэн хамруулсан. Хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан 2025 оны 10 дугаар сарын 20ны өдрөөс ЭХЭМҮТ-д хүүхдийн эмчээр төгссөн 1 эмчийг шинээр ажилд авч нийгмийн асуудлыг шийдвэрлэн дүүргийн ЗДТГ-аас олгох орон нутгийн нэмэгдэлд | 100 |
| | | - | Дадлагажуулах сургалтад хамрагдсан эмч нарын тоо | | 2 | | |
| 3.20 | Шинээр ажилд орсон сувилагч нарыг шинэ сувилагчийн хөтөлбөрт хамруулна. | | Шинээр ажилд орсон сувилагчаас сургалтад хамрагдсан хувь | | 100 | Сувиалхуйн багаас шинээр ажилд орсон болон урт хугацааны амралттай байсан сувилагч нарыг ажлын байранд дадлагажуулах хөтөлбөрийг батлулан хэрэгжилтийг ханган ажиллаж хэвшүүлсэн.<br>2025 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар шинээр ажилд орсон 1 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сувилагч, жирэмсний амралттай байсан 2 сувилагч ажилдаа орсон.<br>Эмнэлгийн тусламж үйлчилгээ болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинэчлэлийг таниулах сургалтыг 3 удаа зохион байгуулж хүний нөөцийн ажилтан программ хангамж, ахлах сувилагч ажлын байранд мөрдөгдөж байгаа тушаал шийдвэрийг танилцуулсан. | |
| | | | Шинэ сувилагчаас үзүүлсэн тусламж, үйлчилгээтэй холбоотой таагүй ба ноцтой тохиолдлын тоо | | 0 | Сувилахуйн тусламж үйлчилгээнд ноцтой зөрчил бүртгэгдээгүй. | 95 |
| **Зорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** - Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, барилга, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, автомашин ашиглалт, засвар үйлчилгээ нөхөн хангалтыг нэгтгэн зохион байгуулна. /НХТЖТ-2.11.1/ | | | | | | | |
| 4.1 | Эрүүл мэндийн сайдын А/566 дугаар тушаалыг хэрэгжилтийг хангаан эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг чиглэлээр төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаан ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 95 | 95 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах 2025 оны төлөвлөгөөг 10 бүлэг 33 заалтаагаар боловсруулан байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг хангаан ажиллаж байна төлөвлөгөөний хэрэгжилт 96%-тай хэрэгжсэн.<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд:<br>- Байгууллагын даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс их эмч Б.Төмөрийг чанарын менежерээр томилж, 05 дугаар сарын 07-ны өдрийн А/17 дугаар тушаалаар чанарын багийн гишүүдийн бүрэлдэхүүнийг шинэчлэн | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан.<br>- Эмнэлгийн тусламж үйлчилгээний үйл ажиллагаанд удирдамжтай 7 удаагийн хяналт, явцын хяналтыг 31 удаа хийснээр - Тохиолдол 1А- 7 - Алдах дөхсөн тохиолдол 1Б-2 - Таагүй тохиолдол 1 тус тус илрүүлэн тухай бүрд арга хэмжээг аван ажиллаж байна<br>- Яаралтай тусламжийн багийг 6 хүний бүрэлдэхүүнтэй шинэчилэн байгуулан ахлагч Л.Пагмадулам томилон ажиллуулсан. Яаралтай тусламжийн багаас сувилагч болон туслах сувилагч нар амиллуулах суурь тусламж болон лавшруулах тусламжийг сургалтыг 14 хоног тутам зааж ажлын байранд дахь дадлагыг 7 удаа зохион байгуулсан байна. Мөн яаралтай тусламжийн өрөөний зохион байгуулалтыг шинэчилэн шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гарган шинэчилэн ажилласан.<br>-Яаралтай тусламжийн цогц менежмент сургалтыг Нийслэлийн түргэн тусламжийн төвтэй хамтран 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж эмч, сувилагч, ажилчид бүрэн хамрагдсан. Тус сургалтанд 1,950,000 төгрөг зарцуулсан.<br>-Байгууллагын даргын 2025 оны А/54 дүгээр тушаалаар 23 нэгжид дэмжлэгт хяналтыг 2 удаа зохион байгуулж нийт 19 зөрчлийг арилгуулж бэлэн байдлыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хангаж ажилласан. | |
| 4.2 | Лабораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор нэр төрлийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг судалж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлнэ. | - | Нэмэгдсэн нэр төрлийн тоо | 2 | 1 | Лабораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор:<br>-Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 24,278,125 төгрөгний өртөгтэй цусны хагас автомат анализаторийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүлээн авч тусламж үйлчилгээндээ ашиглаж байна. Тус аппаратны хяналтыг 1 удаа нийлүүлсэн байгууллага Итгэл эрүүл мэнд ХХК-аар хийлгэсэн.<br>-Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 39,337,000 төгрөгний өртөгтэй биохимийн аппаратыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Сүвэн Уул ХХК-ны инженерүүд ирж угсралт, тохиргооны ажлыг хийж ажилласан ба 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 100 |
| 4.3 | Яаралтай, түргэн тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж, дуудлагын хүлээгдэл, чирэгдлийг бууруулна. | - | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 1 | Яаралтай болон түргэн тусламжийн чанарыг сайжруулах зорилгоор:<br>- Байгууллагын дотоодын сургалтаар эмч, эмнэлгийн ажилчдыг чадавхжуулах яаралтай тусламж, эрэмбэлэн ангилалт, амилуулах тусламж үйлчилгээний сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт давхрадсан тоогоор 74 ажилтан хамрагдсан.<br>- Багануур эрүүл мэндийн төвтэй хамтран туршлага солилцох уулзалтыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж яаралтай тусламж, түргэн тусламж, эрчимт эмчилгээний тасгийн үйл ажиллагаатай танилцаж уулзалт ярилцлагыг 1 удаа хийсэн. Тус арга хэмжээнд 5 ажилтны бүрэлдэхүүнтэй оролцосон.<br>Яаралтай тусламжийн цогц менежмент сургалтыг Нийслэлийн түргэн тусламжийн төвтэй хамтран 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж эмч, сувилагч, ажилчид бүрэн хамрагдсан. Тус сургалтанд 1,950,000 төгрөг зарцуулсан. | |
| **Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт -** Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр хувийн хэвшлийг түншлэлийг эрчимжүүлж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахимжуулах ажлыг сайжруулна | | | | | | | |
| 5.1 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, чанарыг хүртээмжийг сайжруулах ажлын үр дүнг тооцож ажиллана. | | Нэмэгдсэн нэр төрөл | 6 | 1 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах ажлын хүрээнд лабораторит хийгдэж байгаа шинжилгээг<br>ШНУГЭ төв эмнэлгийн Эмнэлзүйн лавлагаа лавораторийн гадаад чанарт<br>- Гемотологийн 34 үзүүлэлтээр 96,6%<br>- Цусны бүлэг хувийн тохироо тодорхойлох 100%<br>- Шээсний ерөнхий шинжилгээ - 100%<br>Үнэлгээтэй үнэлэгдэж гэрчилгээ авсан.<br>Сүрьеэ илрүүлэх шинжилгээг дүүрэгтээ хийхээр бэлтгэл ажлыг ханган GeneXpert MTB/RIF аппаратыг Глобал | 100 |
| | | | Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо | - | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сангаас хүлээн авсан ба өрөөний тохижилтыг хийх ажлыг хийж байна.<br>Сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох саналыг дүүргийн ЗДТГ, ЭМДЕГ-т албан хүсэлтээр хүргүүлсэн. | |
| 5.2 | Байгууллагууд хийсэн ажлаа сурталчлах ажлыг цахим болон шинэлэг хэлбэрээр иргэдэд хүргэх сурталчилна | | Зохион байгуулсан ажлын тоо | 7 | 8 | Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, байгууллагын үйл ажиллагаанд тусгах, мэдээ мэдээллээр хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэх ажлын хүрээнд :<br>- Байгууллагын танилцуулгыг шинээр цахимаар хийсэн.<br>- Дүүргийн Засаг даргын шуурхай зөвлөгөөн дээр байгууллагын үйл ажиллагааны танилцуулгыг хийсэн.<br>- НЭМГ-тай Сувилахуйн тусламж үйлчилгээг танилцуулах өдөрлөг 2025.04.10 ны өдөр Соёлын төв өргөөнд зохион байгуулж, тус арга хэмжээнд байгууллагын үйл ажиллагаа, Сувилахуйн тусламж үйлчилгээг сурталчлах, хүний нөөцийн сул ажлын байрны мэдээллийг хүргэх, ажилчдын нийгмийн баталгаа, байгууллагын давуу тал, 2025 онд сувилахуйн тусламж | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээнд хэрэгжүүлж байгаа шинэлэг ажил зэргийг танилцуулж, эрүүл мэндийн байгууллагаас харилцан туршлага судалж, өөрийн байгууллагад нутагшуулж,түгээн дэлгэрүүлэх зорилгоор оролцсон.<br>- Байгууллагын үйл ажиллагаа, хийсэн ажлын танилцуулгыг тусламж үйлчилгээ тус бүрээр хийж видео контент хэлбэрээр 4 төрлөөр хийн иргэдэд түгээх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Эрүүл мэндийн боловсрол олгох эрүүл мэндийн цагийг эмэгтэйчүүдийн эмчээр 7 хоног бүрийн баасан гаригийн 10 цагт хийж хэвшүүлэн болон тус сургалтаар байгууллагын үйл ажиллагааны онцлох ажлыг танилцуулж иргэдээс санал хүсэлтийг авах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Энэ арга хэмжээг 6 удаа зохион байгуулсан. | |
| 5.3 | Төвөөс алслагдсан иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ, мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэх ажлыг цахимаар, бусад байгууллагуудтай хамтран ажиллах ажлыг эрчимжүүлнэ. | | Зохион байгуулсан ажлын тоо | 3 | 3 | Засаг даргын 2025 оны “Иргэн таны сонсъё” өдөрлөгийг зохион байгуулах А/95 дугаар захирамжийн хүрээнд 05 дугаар сарын 27-ны өдөр арга хэмжээнд 6 төрлийн үйлчилгээг үзүүлж нийт давхардсан тоогоор 58 иргэнд үйлчилсэн. | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төвөөс алслагдсан өртөө зөрлөг хөдөөгийн малчдаар 2 удаа явж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан.<br>Нэмэлт дархлаажуулалтын ажлын хүрээнд байгууллагаас 3 хүний бүрэлдэхүүнтэй баг 2 өдөр төвөөс алслагдсан өртөө зөрлөг, хөдөөгийн малчдаар явж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж 38 иргэнд үзлэг хийж 29 хүүхдийг дархлаажуулалтанд хамруулсан. | |
| 5.4 | Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг хангаан ажиллана. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | 100 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын<br>МУЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангаан байгууллагын санхүүд хөтлөгдөх анхан шатны бичиг баримтыг хөтлөж, тавигдах шаардлагын дагуу төсвийн зарцуулалт зохицуулалтыг хийж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг гаргаж, өр авлагийн тайланг хавсарган сар бүр тайлагнаж ажилласан. | 95 |
| 5.5 | Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, төрийн өмчийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, тайлагнаж ажиллана. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | 100 | Байгууллагын даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/22 дугаар тушаалаар эд хөрөнгийн болон эмийн хагас жилийн тооллогыг 2025 оны 06 дугаар сарын 09-нөөс 06 дугаар сарын 20-ны дотор зохион байгуулж, 06 дугаар | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 25-ны дотор тайлагнахаар ажлын 2 хэсэг томилогдон үүрэг чиглэл ажиллаж байна.<br>Байгууллагын жилийн эцсийн тооллогыг зохион явуулах ажлын хэсгийн А/65 дугаар тушаалаар томилон үүрэгжүүлэн ажилласан. | |
| 5.6 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад санхүүгийн мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт бэлтгэн мэдээлж ажиллах ба хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг бууруулж ажиллана. | | Мэдээний тоо | 169 | 171 | Санхүүгийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээ тайлан мэдээллийг тухай бүр холбогдох маягтын дагуу гарган шилэн дансны сайтанд сарын бүрийн 8-ний дотор байршуулж ажилласан. | 95 |
| 5.7 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнаж ажиллана. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | 100 | Лабораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор:<br>-Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 24,278,125 төгрөгний өртөгтэй цусны хагас автомат анализаторийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүлээн авч тусламж үйлчилгээндээ ашиглаж байна. Тус аппаратны хяналтыг 1 удаа нийлүүлсэн байгууллага Итгэл эрүүл мэнд ХХК-аар хийлгэсэн.<br>-Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 39,337,000 төгрөгний өртөгтэй биохимийн аппаратыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Сүвэн Уул ХХК-ны инженерүүд ирж угсралт, тохиргооны ажлыг хийж ажилласан ба 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлыг хангаж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж байна. | |
| 5.8 | “Сайн туршлага 2024” арга хэмжээнээс тусгайлан заагдсан бүтээлийг хэвшүүлэх | | Хэвшүүлсэн бүтээлийн тоо | - | 2 | Сайн туршлага 2024” арга хэмжээнээс тусгайлан заагдсан бүтээлийг жирэмсний өврийн дэвтэр, чихрийн шижингийн хоололтын зөвлөгөө, хөнгөвчлөх сувилахуйн асаргаа сувиллагааны иж бүрдэл эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэн хэвшүүлсэн. | 90 |
| 5.9 | Чихрийн шижингийн кабинетийг байгуулах | - | Кабинетыг байгуулж үйл ажиллагааг эхлүүлсэн байна | | 1 | Амбулаторийн тусламж үйлчилгээнд тулгуурлан тус кабинетийг байгуулахаар төлөвлөг судалгаа, шаардлагатай төсөв тооцооллыг хийж байна. | 80 |
| 5.10 | Байгууллагын үйл ажиллагаанд тохируулан эрүүл мэндийн мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын багийг орон тоогоор тогтвортой ажиллуулна. | - | Чанарын багийн гишүүдийн ажилласан дундаж сар | | 3 | Байгууллагын даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс их эмч Б.Төмөрийг чанарын менежерээр томилж, 05 дугаар сарын 07-ны өдрийн А/17 дугаар тушаалаар чанарын багийн гишүүдийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан.<br>Чанарын багийн гишүүдийг чадваржуулах зорилгоор Чанарын хөгжлийн сургалтанд 1 их эмч, 1 сувилагч хамруулж сургалтын төлбөрт 720,000 төгрөг байгууллагаас хариуцсан. | 90 |
| 5.11 | MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах | - | Гадаад орчны шаардлагын | - | 100 | MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлага стандарт хэрэгжүүлнэ. | | хэрэгжилтийн хувь | | | стандарт хэрэгжилтийг ханган зогсоолын таних тэмдэг, гадна орчны чиглэл маршрутийн мэдээллийн самбар зэргийг хийж байршуулсан. .<br>НЭМГ, дүүргийн ЗДТГ-аас хамтарсан гадна орчны 2 удаагийн хяналт үнэлгээнээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь хэрэгжүүлж тайлагнаж ажилласан.<br>Гаднаад орчны хэрэгжилт 89%-тай | |
| | | - | Дотоод орчны шаардлага хэрэгжилтийн хувь | - | 100 | MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага стандартын хэрэгжилттийг ханган Байгууллагын гадна болон дотор камерыг хэвийн үйл ажиллагааг ханган зорилгоор Ихэр зориг ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Байгууллагын гадна болон дотор камерыг хэвийн үйл ажиллагааг ханган зорилгоор Ихэр зориг ХХК-тай хамтран ажиллах гэрээг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй орчин бүрдүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс сэргийлж, оюулгүй орчинд тусламж үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлж дотор хэсэгт 3 камерыг нэмж суурилуулж нийт дотор 19, гадна талдаа 5 камерын үйл ажиллагааг бүрэн ажилуулж байна. Камерын ажлыг Ихэр зориг ХХК хийж гүйцэтгэсэн. | 91 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Камерын үйл ажиллагаанд 2025 оны 5,670,000 төгрөг зарцуулсан.<br>Унах эрсдлээс сэргийлж 3 санамж зөвлөмжүүдийг шинээр нэмж байршуулсан.<br>Тасгийн ариун цэврийн өрөөнд 5 бариулыг байршуулсан.<br>Шатрын хөвгүүд ХХК-тай хамтран гэрээ байгуулан лифтний засвар үйлчилгээнд 5,764,000 төгрөг зарцуулж үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажилласан.<br>Дотоод орчны хэрэгжилт 96%-тай байна. | |
| 5.12 | Харьяалах нутаг дэвсгэрийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг эх барих эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна. | - | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо | 1046 | 1046 | Эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр эмэгтэйчүүдийн 1 их эмч, эх баригч бага эмч -1 нийт 2 оронтойгоор тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.<br>2025 оны 11 дүгээр сарын 01-ны байдлаар нийт жирэмсний хяналтанд 53 жирэмсэн орсон эхний 3 сартай хяналт 44 буюу 83 хувьтай хяналтанд орсон жирэмснээс В,С вирус болон ХДХВ тэмбүүгийн өвчлөл илрээгүй байна.<br>Мөн онцгой хяналтанд байсан 2 ихэр жирэмсэн-2, хавсарсан эмгэг өөрчлөлттэй -6 нийт -6 жирэмсний хяналтыг дээд шатны эмнэлгийн хамтран хийж, 2 эх эсэн мэнд амаржсан.<br>Эмэгтэйчүүд гэр бүлийнхэнд зориулсан | 95 |
| | | | үүнээс үзлэгт хамрагдсан тоо | 349 | 740 | | |
| | | | Үзлэгийн хувь | 35 | 70 | | |
| | | - | Эрүүлжилтийн хувь | % | % | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 51 иргэнд хамруулсан.<br>-Төрөх насны 15-45 насны эмэгтэйчүүдийн судалгааг нарийвчлан гаргаж 152 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан.<br>-Зорилтот бүлгийн 138 эмэгтэйчүүдээс 87 эмэгтэйг жирэмснээс хамгаалах эм , тариа , суулгацанд хамруулснаар эрсдэлт бүлгийн иргэдийн 63 хувийг жирэмснээс сэргийлэх аргад суралцуулан урьдчилан сэргийлэн ажилласан. | |
| 5.13 | Хяналтгүй болон гэрийн төрөлт, амьгүй төрөлт, өсвөр насны хүүхдийн төрөлт, үр хөндөлтөд жирэмсний хяналтад ороогүй зэрэг шалтгаанд дүн шинжилгээ хийж, нөлөөлж буй хүчин зүйлийг судлан түүний мөрөөр давтан гарахаас сэргийлэх ажлыг зохион байгуулна. | - | Шалтгаан илрүүлэх талаар боловсруулсан асуумжийн тоо | - | 1 | Төрөх насны эмэгтэйчүүдийн судалгааг 2025 оны байдлаар шинэчилэн гаргаж дүгнэлт хийж ажиллаж байна. Зорилтот бүлгийн 32 эмэгтэйтэй 1 удаагийн уулзалт ярилцлага хийж ажилласан.<br>Эмэгтэйчүүдийн эсэн мэнд амаржихуй, жирэмсний болон дараах үеийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр 7 хоногийн Баасан гаригийн 10 цагийг эмэгтэйчүүдийн цаг болгон сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж эхлүүлээд байна.<br>Эмэгтэйчүүд гэр бүлийнхэнд зориулсан 6 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 51 иргэнд хамруулсан | 90 |
| | | | Судалгаанд | 1 | 0 | Судалгаанд 936 иргэн хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамрагдсан хүний тоо | | | | |
| | | | Шалтгаан бууруулах талаар хийгдсэн төлөвлөлт хэрэгжилтийн хувь | - | 95 | 2025 оны байдлаар гэрийн хяналтгүй - 1 буюу /5,5%/ байна. Судалгаа хийж ажиллахад дүүргийн харьяалалтай хөдөө орон нутагт сурдаг оюутан байсан тул цаашид харьяалалтай боловч өөр газар амьдардаг төрөх насны эмэгтэйчүүдэд анхаарч хяналт тавьж ажиллах , утсаар эргэмж холбоотой ажиллах талаар анхаарч ажиллах талаар эмч нартай хурал зохион байгуулан зөвлөмж боловсруулсан. Цаашид эмэгтэйчүүд, төрөлттэй холбоотой асуудлыг сайжруулахаар 11-р сараас эмэгтэйчүүдийн их эмч шинээр авч ажиллуулсан. | 90 |
| | | | Амьгүй төрөлтийн тоо | 0 | 0 | 2025 оны эхний 11 сарын30-ны байдлаар амьгүй төрөлт гараагүй. | 100 |
| | | | Гэрийн төрөлтийн тоо | 0 | 0 | 2025 оны 11 сарын 30-ны 2 тохиолдол буюу 3,8%-байна. Цаашид нэмэгдүүлэхгүй байх тал дээр анхаарч ажиллахаар эмэгтэйчүүдийн их эмч, бага эмч нарт зөвлөгөө өгч , эмч нарын дунд хэлэлцүүлэг нэг удаа зохион байгуулсан. | 90 |
| | | | Хяналтгүй төрөлтийн тоо | 0 | 0 | 2025 оны 11 сарын 30-ны 3 тохиолдол буюу 5,8%-байна. Цаашид нэмэгдүүлэхгүй байх тал дээр анхаарч ажиллах мөн дүүрэгт харьяалалтай | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрнээ УБ хот болон хөдөө орон нутагт амьдардаг төрөх наснб эмэгтэйчүүдийн судалгааг тусад нь гаргаж , утсаар эргэмж холбоо үүсгэн ажиллах талаар зөвлөгөө өгч ярилцлага зохион байгуулсан. | |
| | | | Эхийн эндэгдэлийн тоо | 0 | 0 | 2025 оны эхний 11 сарын 30-ны байдлаар эхийн эндэгдэлгүй ажилласан. | 100 |
| | | | Өсвөр насны хүүхдийн төрөлтийн тоо | 0 | 0 | 2025 оны 11 сарын 30-ны байдлаар 17 настай 1 ээж төрсөн ба хяналт хэвийн хийгдсэн. | 100 |
| 5.14 | Дүүргийн 0-18 насны хүүхдийн судалгаан дээр үндэслэн 0-5 насны хүүхдийн эрсдэлт бүлгийн судалгааг шинэчлэн гаргана. | - | Эрсдэлийн шинэчилсэн бүртгэл судалгаа | - | 2 | 2025 оны 11 сарын 30-ны байдлаар 0-18 насны 721 хүүхдийн эрсдлийн судалгааг 2 удаа шинэчилсэн гаргаж дүгнэлт хийж ажиллаж байна.Одоогоор эрсдэл тодорхойлогдоогүй байна. | 95 |
| | | | Гэрийн эргэлтийн хувь | 3.1 | 8,8 | 2025 оны 11 сарын 30-ны байдлаар нийт 41637 үзлэгээс гэрийн эргэлтийн үзлэг 3689 буюу 8,8%-тай байна. | 100 |
| | | | Гэрийн эргэлтийн хэрэгжилтэд хяналт хийсэн хяналтын тоо, хяналтад хамрагдсан өрхийн тоо | 1598<br>296 | 3689<br>356 | Гэрийн эргэлтийг сайжруулах талаар дотоод хяналтын 2 удаа зохион байгуулан ажилласан. Цаашид гэрийн эргэлтийг сайжруулах талаар эмч нар болон сувилахуйн багийн гишүүдэд 1 удаа зөвлөгөө өгч ярилцлага зохион байгуулсан. Мөн эмч нарт хуваарь 7 хоног бүрээр хийж өгсөнөөр гэрийн эргэлтийн хувь сайжирсан. | 97 |
| | | | Хяналтаар илэрсэн дутагдлыг арилгах | 90 | 95 | 6 удаагийн хяналтыг дотооддоо зохион байгуулж, 7 дутагдлыг илрүүлж, дутагдлыг засах ажлын төлөвлөгөө | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | талаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь | | | боловсруулан хяналт тавин ажиллаж байна. | |
| | | | 0-5 насны хүүхдийн эндэгдэлийн тоо | 27.4 | 0 | 2025 оны 11 сарын30-ны байдлаар 0-5 насны хүүхдийн эндэгдэлгүй ажиллаж байна. | 100 |
| 5.15 | Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдлийн шалтгаанд дүн шинжилгээ хийж, нөлөөлж буй хүчин зүйлийг судлан түүний мөрөөр давтан гарахаас сэргийлэх ажлыг зохион байгуулна. | - | Шалтгаан, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийг судлан эрсдлийн үнэлгээ хийж хэлэлцсэн хурлын тоо | 2 | 4 | 2025 оны 11 сарын 30-ны байдлаар тохиолдол бүртгэгдээгүй. Урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 удаагийн сургалт зохион байгуулан 117 иргэний хамруулсан. | 100 |
| | | | Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдлийн шалтгаан, хүчин зүйлийг бууруулах талаар хийгдсэн төлөвлөлт, хэрэгжилтийн хувь | 0 | 0 | 2025 оны 11 сарын 30-ны байдлаар эмнэлгийн бус нөхцөлд эндэгдэл бүртгэгдээгүй. | 100 |
| | | | Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн тоо, хувь | 0 | 0 | 2025 оны 11сарын 30-ны байдлаар тохиолдол бүртгэгдээгүй. | 100 |
| | | | Нийт 0-5 насны хүүхдийн дунд | 27,4 | 0 | 2025 оны 11 сарын 30-ны байдлаар тохиолдол бүртгэгдээгүй. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хяналтгүй нас баралтын тоо | | | | |
| 5.16 | Хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхэдтэй ар гэр, асран хамгаалагч нарын хүүхдээ хөгжүүлэх, дэмжих, мэдлэг ур чадвар дадлыг үнэлэн, хүүхэд бүрийн онцлогт тохирсон хөгжлийн дэмжлэгийн богино болон урт хугацааны төлөвлөгөөг гарган, үр дүнг тооцож ажиллана. | - | Хүүхдийн сэргээн засах төвд илгээсэн хөгжлийн бэрхшээл, хоцрогдолтой хүүхдийн тоо | | 3 | Амбулаторийн тусламж үйлчилгээнээс 4 хүүхдийн Бяцхан тэмүүлэн сэргээн засах төвд илгээж үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамруулсан.<br>1 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн. | 95 |
| 5.17 | Лабораторийн шинжилгээний төрөл тус бүрээр үндэсний чанарын гадаад хяналтад тогтмол хамрагдаж, үнэлгээний дүнг нэмэгдүүлнэ. | - | Гематологийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээний хувь | 90,8 | 92 | Гематологийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээг хийлгэхээр Интернмед эмнэлэг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр гадаад чанар хамрагдсан ба 96.6% үнэлэгдсэн.<br>Гадаад чанарын үнэлгээний төлбөрт 63000 төгрөг азрцуулсан.<br>Сүүлийн хагас жилийн гадаад чанарт нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2025 оны 09 дүгээр сарын 01 ний өдөр хүлээн авсан гематологийн аппаратыг хамруулахаар 12 дугаар сарын 02ны өдөр сорьцыг хүлээн авч 12 сарын 08-ны дотор хариуг хүргүүлэхээр ажиллаж байна. | 100 |
| | | | Биохимийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээний хувь | 70 | 75 | Биохимийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээг хийлгэхээр Улсын гуравдугаар Төв эмнэлэг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хамрагдаж харьцангуй үнэлгээг 70%, үнэмлэхүй үнэлгээ 68,% үнэлэгдсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гадаад чанарын үнэлгээний төлбөрт 260000 төгрөг азрцуулсан. | |
| | | | В вирусийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээний хувь | - | 80 | Халдварт Өвчин судлалын үндэсний төвийн иммунологийн лабоаторит гадаад чанарын үнэлгээг хийлгэхээр 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хамрагдаж 70% үнэлэгдсэн. | 100 |
| | | | С вирусийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээний хувь | - | 80 | Халдварт Өвчин судлалын үндэсний төвийн иммунологийн лабоаторит гадаад чанарын үнэлгээг хийлгэхээр 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хамрагдаж 70% үнэлэгдсэн. | 100 |
| | | | ДОХ-ын шинжилгээний шинжилгээний чанарын гадаад үнэлгээний хувь | - | 80 | Халдварт Өвчин судлалын үндэсний төвийн иммунологийн лабоаторит гадаад чанарын үнэлгээг хийлгэхээр 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хамрагдаж 70% үнэлэгдсэн. | 100 |
| | | | Тэмбүүгийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээний хувь | - | 80 | Халдварт Өвчин судлалын үндэсний төвийн иммунологийн лабоаторит гадаад чанарын үнэлгээг хийлгэхээр 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хамрагдаж 95% үнэлэгдсэн. | 100 |
| | | | Цусны бүлэг тодорхойлох | 87,5 | 89 | Цус судлалын үндэсний төвийн лаборатори цусны бүлэг тодорхойлох гадаад чанарын үнэлгээг хийлгэхээр холбогдох материалыг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хамрагдаж 100 үнэлэгдсэн. | 100 |
| | | | Цусны хувийн тохироо тодорхойлох | 87,5 | 89 | Цус судлалын үндэсний төвийн лаборатори цусны бүлэг тодорхойлох гадаад чанарын үнэлгээг хийлгэхээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдох материалыг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хамрагдаж 100 үнэлэгдсэн. | |
| | | | Шээсний шинжилгээний чанарын гадаад үнэлгээний хувь | 100 | 100 | Улсын нэгдүгээр төв эмнэлгийн лавлагаа лабоарторит шээсний шинжилгээний чанарын гадаад үнэлгээг хийлгэхээр холбогдо материалыг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр хамрагдаж 100 хувь үнэлэгдсэн | 100 |
| 5.18 | Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын өдрийг дүүрэгт зохион байгуулж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ. | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | 1 | Дүүргийн Улаан загалмай, ИТХ-тай хамтран 2025 оны 10 дугаар сард сайн дурын авлагагүй донорын өдрийг дүүрэгтээ зохион байгуулан ажилласан Үүнд 58 иргэд ,албан хаагч цусаа хандивласан. | 100 |
| 5.19 | Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний сургалтад эмч, сувилагч нарыг хамруулах, мэргэшсэн хүний нөөцөөр хангаж ажиллана. | | Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний сургалтад хамрагдсан эмч, сувилагчийн тоо, хувь | | 2 | Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний сургалтад эмч, сувилагчийг сурган ажилласан.<br>Мөн уламжилалт , сэргээн засах , ардын эмчилгээний сургалтанд их эмч Б. Төмөрчөдөр , сэргээн засах сувилагч С. Олзбаяр нар хамрагдаж, 2025 оны 9 сараас цай эмчилгээний аргыг нэвтрүүлэн сайн туршлага-2025 арга хэмжээнд амжилттай оролцсон. | 95 |
| 5.20 | Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн үзлэгийн богино болон урт хугацааны эрүүлжилтийн хувийг нэмэгдүүлэх чиглэлээр ажлуудыг зохион байгуулж ажиллана. | | 1,2-р ээлжний богино хугацааны эрүүлжилтийн хувь | 30 | 40 | 2024 оны 02 дугаар ээлжийн цэрэг татлагаас эрүүл мэндээр хасагдсан 40 залуучуудаас богино хугацаанд эмчлэгдэх боломжтой 2 иргэнийг хяналтанд авч эмчилгээнд хамруулснаар эрүүлжүүлэлт 100 хэрэгжиж 2025 оны 02 дугаар ээлжийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэрэг татлаганд тагдсан. | |
| | | | 1,2-р ээлжний урт хугацааны эрүүлжилтийн хувь | - | 10 | 2025 оны 02 дугаар ээлжийн цэрэг татлагаас эрүүл мэндээр хасагдсан 29 залуучуудаас 27 залуучуудыг хяналтанд авсан.<br>2025 оны 11 дүгээр сарын 28 ны өдөр Цэргийн төв эмнэлэг, дүүргийн ЗДТГ-тай хамтран 18 залуучуудыг давтан үзлэгт хамруулж 11 залуучуудыг эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн албанд тэнцэхгүй дүгнэлт гаргуулсан. | 100 |
| 5.21 | Гамшгийн үед хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай зохион байгуулж тусламж, үйлчилгэний тасралтгүй байдлыг хангаж ажиллана. | | Оролцсон тусламж үйлчилгээний тоо | | 2 | Байгууллагын “Гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн анги байгуулах тухай” бүрэлдэхүүнийг даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар шинэчлэн батласан.<br>Байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/02 дугаар ташаалаар Менингококкт халдварын бэлэн байдлыг хангаж, эмчилгээ, ялган оношлогоо, хариу арга хэмжээг төлөвлөж бэлтгэл ажлыг ханган, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн ажилласнаар дүүргийн нутаг дэвсгэрт өвчлөл бүртгэгдээгүй.<br>Байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/03 дугаар тушаалаар Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэжмээг эрчимжүүлэн бэлэн байдлыг хангаж ажилласнаар өвчлөлийн | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүндрэл бүртгэгдээгүй.<br>2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн а/07 дугаар тушаалаар байгууллагын “Шуурхай удирдлагын баг”-ийг томилж, 05 дугаар сарын 30 -ны өдрийн А/20 дугаар тушаалаар тандалтын баг, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх багуудыг томилсон.<br>Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эримжүүлэн, тандалтын хяналт, хавьтлыг тохиолдол бүрт цаг алдалгүй заавар журмын дагуу хийж ажиллаж байна.<br>2025 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар шинжилгээгээр баталгаажсан -2, эмнэлзүй шинж тэмдгээр оношлосон-3 нийт 5 тохиолдлын хяналтыг хийж голомтын дархлаажуулалтанд 10 хүүхдийг хамруулж, 74 хүүхдийг А амин дэмийг уулгасан.<br>Улсын хэмжээнд зарлан явуулсан иж бүрэн үзлэгт байгууллагын 28 ажилтан хувийн аранзтай жагсаж оролцсон.<br>Эрүүл мэндийн яамнаас гамшгийн үеийн бэлэн байдлын дадлага сургуулилтанд штабын дарга, чанарын менежер 2 эмч бүрэн хамрагдсан. | |
| 5.22 | Ахмад настны үзлэгийг зохион байгуулна. | | Эрсдэлд бүлгийн ахмад настанг үзлэгт хамруулсан тоо | 2 | 3 | Дүүргийн хэмжээнд 292 ахмад настан бүртгэлтэй байдгаас ахмадын хороотой хамтран 118 ахмадыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж байгууллагын нөөц бололцоондоо тулгуурлан үзлэг, шинжилгээ, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оношлогоо хийсэн. | |
| | | | Эмчилгээнд хамрагдсан ахмадын тоо | 129 | 170 | 118 ахмадын үзлэгийн үр дүнд:<br>- Лавлагаа шатны эмнэлэгт нарийн шинжигээнд хамрагдах зөвлөгөөг 37<br>- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 29<br>- Амбулаторийн хяналтанд зөвлөгөө өгсөн 27 | 100 |
| 5.23 | Өсөлт хөгжлийн хэмжилт, эрт илрүүлэг, үзлэгээр илэрсэн 0-5 насны хүүхдийн суурь өвчнийг хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна. | | Өсөлт хөгжлийн мэдээ тайлан үнэн бодитой эсэхэд хийсэн хяналтын тоо | 1 | 1 | 2025 оны 11сарын байдлаар 5246 хүүхдийн жин өндрийг үзэж хяналтын үзлэгийг хийж өсөлтийн хоцрогдолтой 2 хүүхдийг хяналтанд авч 1 хүүхдийн байнгын асаргаанд оруулж , 1 хүүхдийг сувилалд явуулсан. | 95 |
| | | | 0-5 насны өвчтэй хүүхэд бүрийг ХӨЦМ-ийн дагуу үнэлж байгаа эсэхэд хийсэн хяналтын тоо | 187 | 290 | Амбулаторт ажиллаж байгаа эмч нарт ХӨЦМ –ийн сургалтыг их эмч Б. Төвшинжаргал 2 удаа сургалт явуулан хяналтыг 1 удаа хийж зөвлөгөө өгч ажилласан. 2025 оны 10-р сараар хүүхдийн нарийн мэргэжлийн эмчтэй болсноор амбулаторийн эмч нарт ажлын байранд дахь дадлага сургалтыг 2 удаа явуулан хяналтийг7 хоног тутам хийж ажиллаж байна. | 97 |
| | | | Хяналтаар илэрсэн дутагдлыг арилгах талаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь | 69 | 85 | Хяналтаар илэрсэн дутагдлыг арилгах талаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, хүүхдийн бүтэн биеийн үзлэгийг сайжруулах , өвчлөлийн суурь судалгааг гаргах , өвчлөл дээр дүгнэлт хийж ажиллах зэрэг зөвлөгөө өгч ажилласан. | 96 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Илрүүлэг, үзлэгээр илэрсэн суурь өвчтэй хүүхдээс хяналтад авсан хүүхдийн тоо, эрүүлжүүлэлтийн хувь | 62 | 87 | Илрүүлгийн үзлэгт 642 хүүхэд хамруулан суурь өвчтэй илэрсэн 13 хүүхдийн эмч хяналтандаа авч ажилласан. Мөн өдрийн эмчилгээ нээх, хэвтүүлэн эмчлэх , нарийн мэргэжлийн үзлэгийг улирал тутам хийлгэх зэрэг асуудлуудыг шийдэн ажиллаж байна. | 95 |
| | Хэрэгжилтийн дундаж хувь | | | | | | 96.8 |

*Төлөвлөгөөг хянасан:* **Төсвийн Ерөнхийлөн захирагч**

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН

ГАЗРЫН ДАРГА ............................................... /Н.НАРАНБААТАР/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

*Төлөвлөгөө тайлагнасан:* **Төсвийн Шууд захирагч**

*БАГАХАНГАЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН*

*ТӨВИЙН ДАРГА* ........................ */Х.ГАНБАТ /*

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................